

**АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ "БҮТЭЭЛЧ АРВАЙХЭЭР"
ХӨТӨЛБӨРИЙН 2019 ОНЫ ХЭРЭГЖИЛТ**

2019.12.09

Арвайхээр сум

№	Бодлогын зорилт, арга хэмжээ	Биелэлт	Үнэлгээ		
<i>1.5 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал /засвар/</i>					
1.	1.5.3 Шинээр ажлын байр олноор бий болгосон, тогтвортой үйл ажиллагаа явуулж, ажлын байраа хадгалан сумын эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулж буй аж ахуйн нэгж байгууллагуудыг дэмжих бодлого баримтлана.	76. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх	2017-2019 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас зээл авч, ажлын байр түрээслэж үйлдвэрлэл, үйлчилгээгээ тогтвортой явуулж байгаа өссөн дүнгээр 19 иргэнд ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлсэн. “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 2017 онд 4 иргэнд нийт 632.0 төгрөг, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 1 иргэнд 87.360 төгрөгийн, 2018 онд ажил олгогчийн дэмжлэгт хамрагдах шалгуур үзүүлэлтийг хангасан 6 аж ахуйн нэгж, 2019 онд 8 аж ахуйн нэгжтэй тус тус гэрээ байгуулан түрээсийн дэмжлэг үзүүлж ажилласан Ажлын байраа тогтвортой хадгалж, ажилчдынхаа нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлж гэрээний заалтыг бүрэн хэрэгжүүлсэн 14 аж ахуйн нэгжид 2018-2019 онуудад ажил олгогчийн дэмжлэгийг ХЭДСангаас олгож, өссөн дүнгээр 11 иргэнийг байнгын ажлын байраар хангаж нийт 16.8 сая төгрөгийн дэмжлэг авсан. Мөн Дэлхийн зөн ОУБайгууллагаас хэрэгжүүлсэн “Өрхийн хөгжил-320” төслийн хүрээнд 78.720.000 төгрөгийн зээл тусламжид хамрагдсан байна. Сум хөгжүүлэх сангаас 2017 онд 31 эмэгтэйд, 123.5 сая, 2018 онд 14 эмэгтэйд 82 сая, 2019 онд 19 эмэгтэйд 128 сая төгрөгийн зээл олгож, жил бүр өссөн дүнтэй эмэгтэйчүүдийн ажлын байрыг дэмжих хөтөлбөрийг бодлогын түвшинд дэмжсэн байна.	100	100
1.	1.5.6 Хөдөлмөрийн зах зээлд нийцсэн мэргэжилтэй ажилтанг мэргэжлийн болон давтан сургалтаар1000-аас доошгүй ажилгүй иргэдийг бэлтгэж, бизнес эрхлэх, ажлын байрыг	83. Мэргэжлийн болон давтан сургалтанд суух иргэдийн судалгааг тодорхойлж, жилд 250-аас доошгүй ажилгүй иргэнийг мэргэжил олгох	2017-2018 онд тариалангийн газрын ашиглалтыг сайжруулах, зах зээлийн эргэлтэд оруулах, сэргээх, хөрсний үржил шимийг нэмэгдүүлэх, бордоог зохистой хэрэглэх зорилт дэвшүүлэн газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх сонирхолтой 181 иргэнийг ногоочныг сургалтад хамруулсан. “Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар олгох” хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэгийн туслах багш, тогооч, оёдолчны сургалтад 81 иргэн, “Цогц төгсөлтийн аргачлал	100	70

	нэмэгдүүлэхэд нь зориулж хүү багатай, хөнгөлөлттэй зээлийн үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.	сургалтанд хамруулах	төсөл"-ийн хүрээнд үсчин гоо сайхан, мужаан, гутал засварын сургалтад 35 иргэнийг хамруулж мэргэжлийн үнэмлэх олгож, мэргэжил олгох сургалтад нийт 236 иргэнийг хамруулсан. 2019 онд Хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээг тодорхойлох, хувь хүний хөгжил сэтгэл зүйн байдал хандлагыг талаарх судалгааны үр дүн болон хөдөлмөр эрхлэх хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нь үндэслэн мэргэжлийн сургалтад /зөөлөн эдлэлийн оёдол эсгүүрчин, тогооч, барилгын засал чимэглэлч/ 15 иргэнийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 3.0 сая төгрөгийг зарцуулсан. Сургалтад хамрагдсан иргэдийн 40 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэж, 30 хувь нь ажлын байраар хангагдсан байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээнд 55 иргэн, бизнес төсөл, боловсруулах арга аргачлалд сургах аж ахуйн эрхлэлтийн сургалтад 65 иргэн хамрагдсан байна. Сумын хэмжээнд гэрийн ажилтай болон хүүхэд өндөр настан асардаг эмэгтэйчүүдэд зориулсан өдөрлөг зохион байгуулж, гэр бүлийн харилцаа, үнэ цэнэ, ёс зүйн чиглэлээр сургалт хийсэн. "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний төв"-ийн нээлтийн үйл ажиллагаанд хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн болон гэрийн ажилтай эмэгтэйчүүдийн төлөөлөл бүхий 260 иргэн сургалтад хамрагдсан.		
2.	1.5.7 Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн зорилтот бүлгийн өрхүүдийгоновчтой тодорхойлж, тэдэнд үзүүлэх нийгмийн үйлчилгээг чанаржуулж, салбар дундын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулна.	85. Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд өрх, иргэдийг хамруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг оновчтой хүргэх	"Орлого орлуулан тооцох аргачлал"-аар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны ажил 2017 оны 03 дугаар сарын 31-нээс 04 дүгээр сарын 09-нийг дуустал орон даяар зохион байгуулагдаж, өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны өрхөөс мэдээлэл цуглуулах өрхийн жагсаалт бэлтгэх үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Сумын хэмжээнд нийт 6906 өрх судлахаас 6473 өрх буюу нийт өрхийн 93.7 хувь нь судалгаанд хамрагдлаа. Үүнээс 409 өрх судалгаанд хамрагдаагүй, 24 өрх татгалзсан. 11 сарын байдлаар 240.3176 онооноос доогуур оноотой 226 өрхийн 1404 иргэн хүнс тэжээлийн үйлчилгээнд хамрагдаж 156.8 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 2017-2018 онд хүүхдийн мөнгийг амьжиргааны түвшин харгалзахгүйгээр бүх хүүхдэд	100	70

			<p>олгосон. Арвайхээр сумын хэмжээнд өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийт 7223 өрх байна. Үүнээс доод түвшин 1202, харьцангуй бага хэрэглээтэй 1856, дундаж бүлгийн 2632, дунджаас дээгүүр 805, илүү өндөр хэрэглээтэй 214 өрх байна. Өрх иргэний өргөдлийг цаг тухайд нь шийдвэрлэж өрхийн мэдээллийн нэгдсэн санг тогтмол баяжуулж ажиллаж байна.</p> <p>Арвайхээр сумын хэмжээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд 2019 оны 12 дугаар сарын байдлаар 904 өрхийн 4720 иргэн хамрагдаж байна. Үүнээс хөдөлмөрийн насны 2435 иргэн, 0-16 насны 2285 хүүхэд байна. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байгаа өрхийн иргэдийг харьяа багийн нутаг дэвсгэрийн хог хаягдал цэвэрлүүлэх, мөн амьдрах ухааны болон сэтгэлгээ хандлагыг өөрчлөх сургалт арга хэмжээнд тогтмол хамруулж байна. 904 өрхийн 4720 иргэнд 2019 оны байдлаар 57,240 сая төгрөгийн олголтыг нийгмийн халамжийн сангаас олгосон.</p>		
3.	1.5.8 Өрхийн мэдээллийн нэгдсэн сан /ӨМНС/-гийн талаар холбогдох төрийн байгууллагуудыг мэдээллээр хангах, олон салбарт ашиглах боломжийг бүрдүүлнэ.	86. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг нийгмийн үйлчилгээнд ашиглаж хэвших	<p>2017 онд өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй болон өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдсан өрхүүдийг оноогоор нь эрэмбэлэн 2017 онд 360 , 2018 онд 409 буюу түүнээс доош оноотой өрхийг амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхөд тооцож шүүхийн шийдвэрийн төлбөр, сурах бичгийн хөнгөлөлт, хүүхдийн мөнгө, хүнс тэжээлийн үйлчилгээ зэргийг эрүүл мэндийн даатгал үзүүлж хэвшсэн.</p> <p>2018 оны 11 дүгээр сарын байдлаар амьжиргааны түвшинтэйгээ санал нийлэхгүй мөн огт судалгаанд хамрагдаагүй, өрх тусгаарласан гэх мэт шалтгаанаар дахин үнэлгээнд хамрагдах хүсэлтэй иргэдийг цаг тухайд нь хамруулж өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгааг 5 удаа зохион байгуулж 255 өрхийг судласан байна.</p> <p>Өрхийн амьжиргааны түвшний 409.679 онооноос доош оноотой өрхийн гишүүн иргэний эрүүл мэндийн даатгалыг үнэгүй бөглөх, сум дундын анхан шатны шүүх болон хууль зүйн туслалцааны төвийн тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх үйлчилгээ үзүүлж байгаа бөгөөд 193 иргэнд тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх тодорхойлолт гаргаж</p>	100	70

			өгсөн байна. Сумын хэмжээнд 409.679-с доош оноотой нийгмийн халамжийн дэмжлэг шаардлагатай 13502 иргэн байна.		
4.	1.5.9 Залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, эрх нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүд, хорих ангиас суллагдсан болон архины хамааралтай иргэд зэрэг зорилтот бүлгүүдэд чиглэсэн төрөл бүрийн сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, олон улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтарч ажиллана.	87. Зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд суурилан сургалт, мэдээлэл, зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах	Сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх чиглэлээр зорилтот өрхөөс судалгааг авахад архины хамааралтай хүний тоо 9, гэр орноосоо дайжих зуршилтай хүний тоо 3, гэр бүлийн тайван байдлыг алдагдуулах зуршилтай хүний тоо 6 гэсэн судалгаа гарсан байна. Эдгээр өрхийн иргэдийг Гэр бүл сайн сайхны нийгэмлэг Өвөрхангай аймаг дахь салбар, “Оюуны цэнэг” гэр бүл хүний хөгжлийн академитай хамтран ХХҮГазраас сөрөг зан үйл, хандлагыг өөрчлөх чиглэлийн сургалтад хамруулсан. Зорилтот өрхийн иргэдийн нийгэмд хандах хандлагыг өөрчлөх зорилгоор төрөл бүрийн сургалт арга хэмжээнд өргөн хүрээтэйгээр хамруулж ажиллаа. Дэлхийн Зөн Олон улсын “Өрхийн хөгжил 320” төсөл хөтөлбөрт хамруулсан иргэдийн дунд спортын 5 төрөлт тэмцээн зохион байгуулж, бүлүүд маань идэвх санаачилгаатай оролцсон. “Өрхийн хөгжил 320” хөтөлбөрт хамрагдсан иргэд маань өөр өөрсдийн мэддэг чаддаг зүйлүүдээр тулгуурлан төсөл бичиж, төслийнхөө дагуу сургалтад хамрагдсан. Хувь хүний ур чадвар хандлага, гэр бүл үнэ цэнэ, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөмж, Хүүхэд хамгаалалын тухай хууль, Хөдөлмөр халамж үйлчилгээний нээлттэй хаалганы өдөрлөг, Магадлан итгэмжлэгдсэн Өвөрхангай аймаг дахь Политехникийн коллежийн болон төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд хөдөлмөрийн насны 350 иргэн хамрагдсан. Хөдөлмөр халамж үйлчилгээний дэргэд Залуучуудын үйлчилгээний төвийн нээлт, хөдөлмөрт бэлтгэх сургалт, 15-39 насны 260 залуучууд хамрагдсан. Залуу нас гэрэлт ирээдүй төслийн сургалтад 80 иргэнийг хамруулсан байна. Хүүхдэд ээлтэй орон нутгийн хөтөлбөрийн хүрээнд 0-18 насны эцэг, эхчүүдээс үнэлэлт дүгнэлт авч хэлэлцүүлэгт 54 иргэнийг хамруулсан. Хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сургалтад 84 иргэнийг хамруулсан. Эдгээр сургалт, нээлттэй хаалганы өдөрлөгт хамрагдсанаар тухайн иргэдийн амьдралд өөрчлөл гарч энэ хөтөлбөрт хамрагдсан иргэдийн харилцаа	100	70

			хандлага өөрчлөгдсөн. Халамжийн сангаас тэтгэвэр авагч хөдөлмөрийн чадвар алдалттай 198 иргэнийг эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын хурлаар оруулж хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоосон.		
Тавдугаар бүлэг. Нутгийн удирдлага, эрх зүйн бодлого зохицуулалт /засвар/					
	5.1.2 Төрийн албыг материаллаг бааз, ажиллах орчин нөхцлийг сайжруулж, албан хаагчдыг чадавхжуулан мэдлэг, ур чадварыг дэмжиж, нийгмийн асуудлыг дэс дараатай шийдвэрлэнэ	215. Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхжуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулах	2017-2019 онд Төрийн албан хаагчдыг чадваржуулах, мэргэшүүлэх ажлын хүрээнд сумын ЗДТГазраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг зорилтот сургалтыг төрийн албан хаагчдын дунд зохион байгуулж, давхардсан тоогоор 620 албан хаагчийг хамруулан 2 мэргэжилтнийг Япон, БНХАУ-д улсад мэргэшүүлэх сургалтад тус тус хамруулж чадваржууллаа. ОНЗЗ-ны байгууллага, харъяа төсөвт байгууллагын холбогдох албан хаагчдад 2017 онд шинээр батлагдсан болон шинэчлэн найруулсан хуулиуд, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын танилцуулга, сургалт мэдээллийг хийж, арга зүйгээр хангаж ажиллалаа. ДЗОУБ-ын Өвөрхангай ОНХХ-ийн санхүүгийн дэмжлэгтэйгээр ОНЗЗ-ны байгууллагын албан хаагчдад лектор Л.Найдангийн “Хувь хүний манлайлал”, “Амжилтын хөтөч” сэдвээр 10 цагийн сургалтыг зохион байгуулж, 79 албан хаагч, Удирдлагын Академийн мэргэжил дээшлүүлэх институтын сургалтад 4 албан хаагч, эрх зүйн хөтөч бэлтгэх сургалтад 15 албан хаагч, Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн АЗ сургалтад ОНЗЗ-ны байгууллагын болон харъяа төсөвт байгууллагын 58 алба хаагчийг хамруулж ажлын хариуцлага, ур чадварыг нь нэмэгдүүллээ. Нийгмийн асуудлыг шийдвэрлэх хүрээнд 69 албан хаагчид 11.730.000 төгрөгийн түлшний дэмжлэгийг олголоо.	100	70
		221. Сумын ИТХурлын дэргэдэх “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, шуурхай удирдлагын орон тооны бус зөвлөлийг	Сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2016 оны 2 дугаар тогтоолоор “Иргэний танхимын ажиллах журам”-ыг шинэчлэн батлаж, журмын дагуу үйл ажиллагаа тогтмол явагдаж, 2017-2019 онд зохион байгуулах ажлын төлөвлөгөөний дагуу хэлэлцүүлэг 11, багийн ИНХуралдаан18, байгууллагын албан хаагчдын шуурхай хуралдаан 77, ИТХурал, ЗДТГазар, ХЗАлбаны албан	100	100

		ажиллуулах	хаагчид, харъяа төсвийн байгууллага, зорилтот бүлгүүдийг хамарсан сургалт, ажлын хэсгийн хурал 92, нийтийн сонсгол 1 нийт 195 гаруй арга хэмжээнд нийт 9500 гаруй иргэн, албан хаагчид хамрагдаж, иргэдийн оролцоо нэмэгдсэн үр дүнтэй. “Хэрэгчлэгийн зөвлөл”-ийг шуурхай удирдлагын орон тооны бус хэлбэрээр ажиллуулж, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.		
89	5.1.5 “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг тогтмолжуулж, нийгмийн өмнө тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхдээ иргэдийн дуу хоолойг сонсч, саналыг хүндэтгэн шийдвэртээ тусгадаг, тайлагнадаг тогтолцоог бүрдүүлнэ.	222. “Иргэний танхим”-д тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгуулан иргэдийн дуу хоолойг сонсч, саналыг хүндэтгэн шийдвэртээ тусгах, зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, тайлагнадаг тогтолцоог бүрдүүлэх	Төрийн байгууллагын бодлого шийдвэрт иргэдийн саналыг тусгах зорилгоор нийгэмд тулгамдсан асуудлуудаар хэлэлцүүлгийн зохион байгуулж, иргэдээс гарсан санал санаачлагыг холбогдох шийдвэрүүдэд тусган, санал, зөвлөмж, тогтоолыг холбогдох журмын дагуу хяналтанд авч байна. БИНХуралд УИХурлын гишүүн, аймаг, сумын удирдлагууд бүрэн оролцож оролцсон иргэдийн саналын нэгтгэлийг үндэслэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалт, нийгэм эдийн засгийн үзүүлэлтийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх төсөв санхүүжилтийг тухай бүр шийдвэрлэн ажиллаж дараагийн хуралд хэрэгжилтийг тайлагнан ажиллаж Иргэний танхимд зохион байгуулсан ажлууд Арвайхээрийн фэйсбүүк групп, arvaikheer.gov.mn сайтуудад, байрлуулан олон нийтэд мэдээлэгдэж, мэдээлэл, сурталчилгаа сайжирсан.	100	70
9 3	5.1.9 Төрийн байгууллагын үйл ажиллагааг тогтмол сурталчилахад зориулан хөрөнгө төлөвлөж, телевизийн нэвтрүүлэг, улирал тутмын сонин, сэтгүүлийг бэлтгэж, иргэдийг цахим мэдээллээр хангах үйл ажиллагааг сайжруулна.	229. Сумын ЗДТГазрын хэвлэл мэдээллийн техник хэрэгслийг шинэчлэн сайжруулах	Сумын ЗДТГазрын хэвлэл мэдээллийн техник хэрэгслийг шинэчлэн, Компьютер i7-4100, Дэлгэц Asus VA249, Сервер i7-8700k, Hard ssd-120gb, Dell keyboard, YN560 маркын гэрэл зургийн аппаратны гэрэл, VCT-690 маркийн гэрэл зургийн аппаратын хөл гэх мэт техник хэрэгслийн шинэчлэлийг хийж өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байна. Цаашид үйл ажиллагааг сайжруулах, шинэ дэвшилтэт технологи нэвтрүүлэх хүрээнд wifi router, Osmo брэндийн live төхөөрөмжийг нэвтрүүлэх талаар судлажс байна.	100	100
	5.1.12 Хүний эрхийг хангах, авлигын эсрэг	240. Хүний эрхтэй холбоотой хууль	2019 онд Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын ахлах шинжээч Б.Отгонжаргал нь Арвайхээр суманд ажиллаж,	40	40

	<p>үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, захиргааны шийдвэр гаргах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.</p>	<p>тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хөндлөнгийн хяналт тавих ажлыг төрийн бус байгууллагатай хамтран хэрэгжүүлэх</p>	<p>амьдарч буй иргэдэд хүний эрхийн эрх зүйн туслалцаа үзүүлэхээс гадна гомдол хүлээн авч үйлчилгээ үзүүлэн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үйлчилгээний албан хаагчдын цалингийн сүлжээг шинэчлэн тогтоох, төсөв санхүүг нэмэгдүүлэн батлуулах үүрэг чиглэл, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.</p>		
	<p>5.1.15 Олон нийт, цагдаагийн хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах ажлын хүрээнд “Хөршийн холбоо”, “Аддиктологийн баг”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж, олон нийтийн зөвлөл, нөхөрлөл, бүлгэмийн үйл ажиллагааг бүх талаар дэмжин “Архидалтгүй Өвөрхангай” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ</p>	<p>246. Баг бүрт хөршийн холбоог байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулах</p>	<p>Аймгийн Цагдаагийн газраас санаачлан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах, төрийн байгууллага, албан тушаалтан, иргэдийн хамтын ажиллагааг өрнүүлэх зорилгоор сумын хэмжээнд "Хөршийн холбоо байгуулах, ажиллуулах, үр дүнг тооцох журам"-ыг сумын ИТХурлын 2015 оны 26 дугаар тогтоолоор батлуулсан. Баг тус бүрд 2017-2019 онд “Хөршийн холбоо” байгуулан ажиллах талаар БИНХурлууд, багийн иргэдэд тогтмол танилцуулан сурталчилснаар Арвайхээр сумын 4, 6, 7, 8, 10, 11 дүгээр багуудад “Хөршийн холбоо”-г байгуулагдан Цагдаагийн газраас мэргэжил арга зүйгээр ханган, урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөгөөг өгсөнөөр ажлын үр нөлөө дээшлэн ажиллаж байна. Хөршийн холбоод байгуулснаар оршин суугчид, иргэний нийгмийн байгууллагууд, сууц өмчлөгчдийн холбоо, сайн дурын иргэдийн хүч дэмжлэгийг авах, нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагын хамтын ажиллагааны уялдаа холбоог нэмэгдүүлэж, гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, таслан зогсоох, иргэдийн оролцоо, эрх бүхий байгууллага, албан тушаалтны дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа нэгтгэн зохион байгуулснаар гэр, ахуйн хүрээнд үйлдэгддэг орон байрны хулгай, согтуугаар үйлдэгддэг гэмт хэрэгболон ил задгай хог, угаадас асгах, бие засах зэрэгзөрчил буурч нийгмийн хэв журам сахиулах, хотжих соёлд ажилд ахиц гарч, үр нөлөө үзүүлсэн. Сумын ГХУАжлын төлөвлөгөөний дагуу 2018, 2019 онд Хөршийн холбоодод өссөн дүнгээр 3 удаа, 2019 онд хэсгийн ахлагч нарт Цагдаагийн газартай хамтран тус тус сургалт зохион байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулан Хэсгийн ахлагч,</p>	70	70

			Хөршийн холбоодын ахлагч нарт 2.925.000 төгрөгийн урамшуулал олгосон.		
5.1.16	Сумын болзошгүй цагийн байдлын үед хэрэглэх нөөц хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, Гамшгаас хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, мэргэжлийн ангиуд, албадын сургалт дадлагыг тогтмолжууланбэлэн байдлыг хангана.	250. Сумын болзошгүй цагийн байдлын үед хэрэглэх нөөц хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх	2017 онд шүлхий гарсантай холбогдуулж, Голомтод 7 малын эмч, 21 постод 87 хүн, 21 хөдөлгөөнт эргүүл хяналт тавьж, нийт 44 техник, мэргэжлийн ангиудын болон бусад нийт 144 албан хаагчид онцгой байдлын газраас тухай бүр сургалт, мэргэжлийн зөвлөгөө авч ажилласан. Дээрх ажилд сумын орон нутгийн төсвөөс 30100000 төгрөг зарцуулсан.	100	70
		255. Орон нутгийн хөгжилд дотоод, гадаадын хөрөнгө оруулалт татах, үр ашигтай хэрэгжилтийг хангуулах	Аймгийн Засаг даргын дэргэдэх төсөл хөтөлбөрийн багтай хамтран БНХАУ-ын ӨМӨЗО-ны Алшаа аймгийн Эзнээ хошуутай хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, харилцаа тогтоох тохиролцоонд хүрч ноос, ноолууран бүтээгдэхүүн, гар урлал, үйлдвэрлэлийн чиглэлээр 2017 онд 32 иргэн, ААН, 2018 онд 21 иргэн ААН, 2019 онд 34 иргэн жилд 2 удаагийн давтамжтайгаар оролцож 500.0 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн Солонгос улсын Пусан хотод хөдөө аж ахуйн салбарт ажиллах хүч гарган ажиллуулах талаар тус хотын удирдлагуудтай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж 6 сарын хугацаатай гэрээгээр ажиллах 180 иргэнийг бүртгэл хийгдэн сургалтад хамрагдахаар болсон.	70	40

АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР